

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ГУРВАН САЙХАН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Өмнөговь аймаг дахь Гурван сайхан нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 11/22 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, ахлах мэргэжилтэн М.Мөнгөншагай, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Ц.Оюут, О.Сэндэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд дотоод аудит, хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Өмнөговь аймаг дахь Гурван сайхан нисэх буудлын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны төсвийн гүйцэтгэл, зарцуулалт, үр ашгийн байдал, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, албан хэрэг хөтлөлтийн байдал, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой удирдах дээд байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилт, албан даалгаврын биелэлт, гадны байгууллага, иргэнтэй хийсэн гэрээ хэлцэл, худалдан авалт, түүний эрх зүйн үндэслэл, хэрэгжилт, нэгжийн бүтэц орон тоо, цалин хөлсний тооцоолол, албан тушаалын тодорхойлолт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

“Гурван сайхан” нисэх буудал нь ИНҮТ-ийн даргын 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/132 дугаар тушаалын дагуу хөлсөөр ажиллах гэрээт ажилтан-2 /Галч-2/ нийт 37 ажилтантай, мөн оны 01 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх төсвийн зардлын төлөвлөгөө нь нийт 1,269.0 сая төгрөг батлуулж, 1,037.1 сая төгрөгийн зардал гаргаж 231.8 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. “Гурван сайхан” нисэх буудал нь Өмнөговь аймгийн Төрийн аудитын газраас 2020 он, 2021 онд тус тус хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан ба 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелэлттэй гэж дүгнэгдэж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй бөгөөд “дараагийн аудитаар анхаарах асуудалгүй” гэж тэмдэглэсэн байна. Түүнчлэн ДАА-наас 2021 онд хийгдсэн аудитын шалгалтаар өгөгдсөн 23 зөвлөмжийн хэрэгжилт шалгах өдрийн байдлаар 22 зөвлөмж 100 хувьтай, 1 зөвлөмж 90 хувьтай, нийт зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж 99,56 хувьтай буюу хангалттай ба тус нисэх буудлын ажилтнуудын ба ажилтнуудын илүү цагийн бүртгэл, хяналт, баталгаажуулалт, зохицуулалтыг хянан шалгахад зөрүүтэй асуудал илэрсэн.

Дотоод аудит, хяналт шалгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг засаж, залруулах талаар тус нисэх буудалд 11 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА